



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/83

Шивээговь сум

Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоол, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу “Сумын төвийн зам дагуух хашааг хэсэгчлэн шинэчлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шагаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүн:

Л.Чанцалмаа

(Нэрт багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.“Сумын төвийн зам дагуух хашааг хэсэгчлэн шинэчлэх ажил”-ыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг (Ажлын хэсэг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Бадамханд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/70 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42124 232